



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2019 оны 03 сарын 15 өдөр

Дугаар А/164

Ховд

Хөрөнгө гаргах тухай

Төсвийн тухай Монгол Улсын хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь заалт, 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2017 оны 5/03 дугаар тогтоолуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар “Ховд аймгийн ногоон хөгжлийн /2016-2026/ хөтөлбөр”, “Гурван Сэнхэр төвтэй таван од” аялал жуулчлалын хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах, Олон угсаатны соёлын биет болон биет бус өв, язгуур урлаг, цайны соёлыг түгээн дэлгэрүүлэх, патентжуулах, өвлүүлэн үлдээх, сурталчлах, аялал жуулчлалаас орох эдийн засгийн үр ашгийг нэмэгдүүлэх зорилгоор “Цайны зам өв соёлын наадам”-ыг зохион байгуулах бэлтгэл ажлын хүрээнд “ITM-2019” олон улсын аялал жуулчлалын үзэсгэлэнд оролцох зардалд зориулан 4 750 000 төгрөгийг зарцуулсугай.

2. Дээрх арга хэмжээнд зарцуулагдах 4 750 000 төгрөг /дөрвөн сая долоон зуун тавин мянган/-ийг аймгийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 2019 онд хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх төлөвлөгөөний жагсаалтын 5.7-д тусгагдсан арга хэмжээнээс санхүүжүүлж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч /Ч.Багдал/, Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч /С.Гантөмөр/-д тус тус зөвшөөрсүгэй.

3. “ITM-2019” олон улсын үзэсгэлэнд оролцох зардлыг хавсралтаар баталсугай.

4. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга /Д.Энхболд/-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА




Б.ДҮГЭРЖАВ

Zax A/164 Ch

02 00733

Аймгийн Засаг даргын 2019 оны 03 дугаар сарын
15-ны өдрийн А/164 дүгээр захирамжийн хавсралт



**"ITM-2019" ОЛОН УЛСЫН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН
ҮЗЭСГЭЛЭНД ОРОЛЦОХ ТӨСӨВ**

д/д	Үзүүлэлт	Тоо ширхэг	Нэг бүрийн үнэ /төгрөг/	Нийт үнэ /төгрөг/
1	"Цайны зам өв соёлын наадам", "Мөнгөлөг шагшуурга" цас мөсний баярын хөтөлбөр /монгол, англи/	1 000 ш	750	750 000
2	"Цайны зам өв соёлын наадам", "Мөнгөлөг шагшуурга" баярын шторк /англи титль/	2 ш	350 000	700 000
3	CD-ний ном	500 ш	1 000	500 000
4	CD хайрцагны нүүр	500 ш	600	300 000
5	CD дээр бичлэг хуулж, наалт хийх /хайрцагтай/	500 ш	5000	2 500 000
	Нийт			4 750 000

-oOo-